

Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ:

Гаалийн байгууллагын удирдлагын зүгээс хүний нөөцийн удирдлагыг ил тод байдлыг хангах чиглэлд дараах ажил арга хэмжээ зохион байгуулаад байна. Үүнд

ЕГ-ын даргын 2023.02.16-ны А/32 тоот тушаалаар Гаалийн байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, 1445 албан хаагчийн 143 ажлын байрны албан тушаалийн тодорхойлолтыг баталсан.

УЗГ-ын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 488 дугаар “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинчлэн тогтоох тухай” тогтоолоор гаалийн байгууллагын 1670 албан хаагчдын үндсэн цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэв, болон бусад нэмэгдлийн тогтоон шинэчилсэн.

аалийн лабораторит ажилладаг албан тушаалийг хөдөлмөрийн хортой хүнд нөхцөлд тооцож нэмэгдлийг олгож шийдвэрлэсэн.

өрийн албаны зөвлөлийн Зөвлөн туслах ажлын хэсэг гаалийн байгууллагатай хамтран ажилласан зөвлөмж дүгнэлтийг хэрэгжүүлж ажиллаж байна.

аалийн байгууллагаас халагдсан албан хаагчийн гомдлыг хуулийн байгууллагаас гаргасан дүгнэлтийг шийдвэрийг үндэслэн ажилд нь эргүүлэн томилсон-8, Ковидын үеийн хууль дуусгавар болсонтой холбоотой ажлаас чөлөөлөгдсөн 7 албан хаагчийн төрийн жинхэнэ албаны шалгалт өгөх хүртэл түр томилж шийдвэрлэсэн нь хууль хэрэгжүүлэхээр эрмэлзэж байна.

лаанбаатар хот, Замын-үүд дэх гаалийн газруудын үйл ажиллагаатай танилцаж шалган зааварчлах ажлын хэсэг ажиллаж дүгнэлт гаргаж зөвлөмж чиглэлийг гаргасан.

асгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 дугаартай албан бичгийн хүрээнд төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт-61, тусгай шалгалт-88 нийт 149 албан хаагчийг төрийн албаны хуулийн дагуу албан тушаалийн тодорхойлолт тусгай шаардлага хангуулахаар шалгалтад хамруулах ажлыг зохион байгуулж байна.

өрийн албаны зөвлөлийн Гаалийн ерөнхий газрын дэргэдэх “Салбар зөвлөл”-ийг 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр байгууллаа.

Ахмадын байгууллага, ахмадуудтай хамтран ажиллах”, “Ахмадын сан” байгуулж ажиллах журам-ыг ГЕГ-ын даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн А/290 тушаалаар баталлаа.

аалийн байгууллагын хүний нөөцийн удирдлагын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай “Нээлттэй хэлэлцүүлэг”-ийг танхимаар болон цахимаар ГЕГ болон дэргэдэх байгууллага, 18 харъяа газар хороог хамруулан зохион байгууллаа.